



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биокомбинат ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/23/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Болд Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.19 № 07/754
танай _____-ны № _____-т

БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХ-АМАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Биокомбинат ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 93.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 994.0 сая төгрөгөөр өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 27 дугаар зүйлийн 27.1-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Бараа, материалын худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн;
- Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй ;
- Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолын дагуу кадастрын мэдээллийн санд тусгагдсан хэмжээсээр үйлдвэрлэлийн зориулалттай газрын нэгж талбарын хэмжээний өөрчлөлтийг бүртгэлд тусгах шийдвэр гараагүй;
- Орон сууцны зориулалттай газартай холбоотой иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгийн өмчлөл, эзэмшлийн зөрчил үүссэн, газар эзэмших эрхийн хугацаа дууссанг сунгуулаагүй;
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд бүртгэлтэй байгааг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Мал эмнэлгийн ерөнхий газар болон аймаг нийслэлийн мал эмнэлгийн газруудын захиалгаар 7,996.9 сая төгрөгийн өртөг бүхий биобэлдмэлийг борлуулжээ.

Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний О хэвшлээс сэргийлэх вакциныг анх удаа үйлдвэрлэж, компанийн дотоодын лаборатори болон Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораториар чанарын хяналт, шинжилгээ хийлгэсэн байна.

Аудитын гол асуудал

Үйлдвэрлэж буй биобэлдмэлийг гар аргаар савлаж байгаа, технологийн нэг дамжлагаас нөгөө дамжлага руу шилжих процесс задгай орчинд явагддаг, үйлдвэрлэлийн тоног төхөөрмжийн 80-аад хувь нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон зэрэг тулгамдаж буй асуудлууд байна.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор "Шугаман эсийн технологи нэвтрүүлэх" төсөл боловсруулж төслийн саналыг Дэлхийн банкны "Мал аж ахуй эргэлтийг эрчимжүүлэх төсөл"-ийн багт, Вирруссын гаралтай вакцины шинэ үйлдвэр барих төслийг боловсруулж дэлхийн банкны "Ногоон өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй төсөл"-ийн багт тус тус танилцуулж, хэлэлцүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	531,414,675.02	234,644,143.14
1.1.2	Дансны авлага	246,539,370.59	165,502,119.46
1.1.6	Бараа материал	4,389,561,785.75	5,825,769,812.30
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	164,416,200.00	-
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,331,932,031.36	6,225,916,074.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,420,821,918.11	6,499,047,311.64
1.2.2	Биет бус хөрөнгө	4,639,717,480.00	4,630,969,480.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,060,539,398.11	11,130,016,791.64
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	16,392,471,429.47	17,355,932,866.54
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	17,322,824.27	369,740,182.07
2.1.1.3	Татварын өр	28,043,388.33	1,609,907.34
2.1.1.4	НДШ-ийн өглөг	96,615.07	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	10,167,250.00	-
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	55,630,077.67	371,350,089.41
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	630,000,000.00
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	630,000,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	55,630,077.67	1,001,350,089.41
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	2,141,020,492.31	2,141,020,492.31
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,944,423,800.98	8,954,691,884.19
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,601,068,480.00	4,601,068,480.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	650,328,578.51	657,801,920.63
2.3.20	Эздийн өмчийн дүн	16,336,841,351.80	16,354,582,777.13
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	16,392,471,429.47	17,355,932,866.54

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,167,970,218.62	8,148,402,574.30
3	Борлуулалтын өртөг	4,511,729,558.13	6,822,765,571.12
4	Нийт ашиг (алдагдал)	1,656,240,660.49	1,325,637,003.18
6	Хүүгийн орлого	-	23,155,008.61
9	Бусад орлого	81,424,983.68	208,616,156.54
11	Ерөнхий ба удирдлагын зардал	1,044,588,475.00	1,525,714,199.39
12	Санхүүгийн зардал	-	40,430,465.75
13	Бусад зардал	679,042,429.92	-
18	Бусад ашиг (алдагдал)	6,206,666.58	40,020,606.27
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	20,241,405.83	31,284,109.46
20	Орлогын татварын зардал	2,024,140.58	1,609,907.34
21	Татварын дараах ашиг (алдагдал)	18,217,265.25	29,674,202.12
28	Орлогын нийт дүн	18,217,265.25	29,674,202.12
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		(9,108,630.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	776,373,168.06	16,462,885,941.35
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(144,261,854.80)	(144,261,854.80)
3	Залруулсан үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	632,111,313.26	16,318,624,086.55
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				18,217,265.25	18,217,265.25
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	650,328,578.51	16,336,841,351.80
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(13,092,230.00)	(13,092,230.00)
11	Залруулсан үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	637,236,348.51	16,323,749,121.80
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				29,674,202.12	29,674,202.12
15	Ногдол ашигт /төлсөн/				(9,108,630.00)	(9,108,630.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		10,268,083.21			10,268,083.21
	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,141,020,492.31	8,954,691,884.19	4,601,068,480.00	657,801,920.63	16,354,582,777.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,186,319,603.69	8,721,920,030.14
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	6,040,339,976.20	7,933,004,262.62
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		853,829.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	145,979,627.49	788,061,938.52
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	7,119,202,820.29	8,136,036,720.17
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,445,641,305.59	1,108,842,004.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	733,830,532.78	302,957,977.66
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,410,854,624.10	449,712,154.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	323,514,637.94	133,123,892.28
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	582,337,600.00	259,715,850.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	41,685,090.51
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	239,881,609.12	94,605,313.30
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	14,024,715.42	114,750.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	369,117,795.34	5,745,279,688.39
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(932,883,216.60)	585,883,309.97
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	274,385,246.42	49,423,076.61
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		53,660.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,276,794.52	23,155,008.61
	Бусад	269,108,451.90	26,214,408.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,854,397.26	918,433,259.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,921,000.00	918,433,259.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,900,000.00	
	Бусад	4,033,397.26	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	223,530,849.16	(869,010,182.39)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	608,394.54
	Бусад		608,394.54
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	14,252,054.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг		9,108,630.00
	Бусад		5,143,424.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(13,643,659.46)
4	Валютын ханшийн зөрүү		
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(709,352,367.44)	(296,770,531.88)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,240,767,042.46	531,414,675.02
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	531,414,675.02	234,644,143.14

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мян.төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
	2	Шингэн бэлдмэл	литр	125,780.0	126,061.6	(281.6)
	3	Хатаасан бэлдмэл	мян.тун	23,451.8	23,451.8	-
2	1	Нийт орлого	мян.төг	8,204,894.7	8,420,194.3	215,299.6
	2	Үндсэн үйлдвэрлэлийн орлого	мян.төг	8,119,894.7	8,171,557.6	(51,662.9)
	3	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	85,000.0	248,636.7	(163,636.7)
3	1	Нийт зардал	мян.төг	8,200,111.2	8,388,910.2	(188,799.0)
	2	Үйл ажиллагааны зардал	мян.төг	7,840,476.3	8,078,715.4	(238,239.1)
	3	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	74,850.0	310,194.8	(235,344.8)
4	1	Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян.төг	4,783.4	31,284.1	(26,500.7)
5	1	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	3,587.6	29,674.2	(26,086.6)
6	1	Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг	мян.төг	8,260.1	9,108.6	(848.5)
7	1	Их засвар, хөрөнгө оруулалт ТЗБАХ	мян.төг	914,784.9	928,091.3	(13,306.4)
8	1	Нийт өр төлбөр	мян.төг	661,000.0	1,001,350.1	(340,350.1)
	2	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	661,000.0	371,350.1	289,649.9
9	1	Нийт авлага	мян.төг	240,895.0	165,502.1	75,392.8
10	1	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төгрөг	1.0	1.0	-
11	1	Цалингийн сан	мян.төг	3,448,046.7	3,629,818.8	(181,772.2)
12	1	Ажиллагсдын тоо	хүн	234.0	234.0	-
	2	Нэг ажилтаны дундаж цалин /жил/	мян.төг	14,735.2	15,512.0	(776.8)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 114.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хүүгийн орлогын албан татварт төлсөн 2.2 сая төгрөгийг татварын өглөг үүсгээгүй, үйл ажиллагааны бус болон төлбөр хураамжийн зардлаар тайлагнасан байна.	1	2,249.0			1	2,249.0	1	2,249.0				
Тайлант онд төлсөн 1.3 сая төгрөгийн харуул хамгаалалтын төлбөрийг үл хөдлөх хөрөнгийн татварын зардалд бүртгэж, тайлагнасан байна.	1	1,300.0			1	1,300.0	1	1,300.0				
Цэвэр ашгаас ТӨБЗГ-т төвлөрүүлсэн ногдол ашгийг төлбөр хураамжийн зардлаар тайлагнасан байна.	1	9,108.6			1	9,108.6	1	9,108.6				
Компанийн 100 жилийн ойн арга хэмжээ болон зочин төлөөлөгч хүлээн авах, ажилчдын амралт баяр ёслолын арга хэмжээтэй холбоотой 83.4 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд, 9.3 сая төгрөгийг төлбөр хураамж болон бусад зардлаар тайлагнаж бүтээгдэхүүний өртөгт шингээсэн байна.	1	93,641.0			1	93,641.0	1	93,641.0				
Хадгаламжийн хүүгийн орлогыг үйл ажиллагааны бус орлогоор тайлагнасан байна.	1	7,970.0			1	7,970.0	1	7,970.0				
Дүн	5	114,268.6	-	-	5	114,268.6	5	114,268.6	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт залруулагдаагүй 1,087.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 452.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 635.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж зохион байгуулаагүйгээс нийт 452.3 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг 7 удаагийн шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна.	1	452,321.8	-	-	1	452,321.8	-	-	-	-	-	-
Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 592.8 сая төгрөгийн худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй байна.	1	592,827.4	-	-	-	-	1	592,827.4	-	-	-	-
ЗГ-ын 2022 оны 267 дугаар тогтоолын дагуу Кадастрын мэдээллийн сан тусгагдсан хэмжээсээр Үйлдвэрлэлийн зориулалттай газрын нэгж талбарын хэмжээ 108 кв.м-р буурч 134,920 кв.м болсон өөрчлөлтийг тайлан бүртгэлд тусгах хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн ч холбогдох шийдвэр гараагүй байна. Орон сууцны зориулалттай 1200 кв.м газрын 450кв.м газарт хувь хүний хөрөнгөөр 40 айлын орон сууц барьж, 2018 онд ашиглалтад оруулан компанийн 15 ажилтанд хөнгөлөлттэй үнээр, бусад 25-ыг нь зах зээлийн үнээр худалдсан нь иргэн аж ахуйн нэгжийн хөрөнгийн өмчлөл, эзэмшлийн зөрчил үүссэн, газар эзэмших эрхийн хугацаа 2022 оны 05 дугаар сард дууссан, одоогоор сунгагдаагүй, газрын төлбөрийг тус компани төлсөөр байна.	1	42,353.0	-	-	-	-	1	42,353.0	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 569 нэр төрлийн 3,817.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Биокомбинат ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Бэлэн бүтээгдэхүүний өртөг тооцооллын программгүй, Excel программаар гаргасан нь тухай бүр өртгийн тооцоолол, бэлэн бүтээгдэхүүний орлогын бичилтийг хийгээгүй, жилийн эцэст хийсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	5	1,087,502.3	-	-	1	452,321.8	4	635,180.5	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 122.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 122.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 74.7 сая төгрөгийн 8 гүйлгээг, орлогын 47.5 сая төгрөгийн 7 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	122,192.1	-	-	1	122,192.1	-	-
Дүн	1	122,192.1	-	-	1	122,192.1	-	-
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Хэрэглэсэн химийн бодисын сав, баглаа боодлыг устгах байгууллага цөөн, зардал ихтэйгээс агуулахад ихээр хуримтлагдсан, бараа нийлүүлэх гэрээнд сав баглаа боодлын устгал, буцаалт, холбогдох зардлын талаар тусгаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	122,192.1	-	-	1	122,192.1	1	-